

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/160/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл Би Альфа аудит ХХК-ны

Аудитор: Н.Дэмбэрэлдорж

Утас: 70432545

цахим хаяг: ndembee9929@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.5.3 Нэмэлт төсөв.....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.2 Материаллаг байдал .....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
5.1 Төлбөрийн акт .....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ХОВД СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Э.УАТХАН ТАНАА**

2023-02-24 № 02/92  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжилийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулахаргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталж мөрдсөн байна.

Дулаанаар хангах гэрээгээр үүссэн өр төлбөрөөс 194.7 сая төгрөгийг төлж, үлдэх 97.8 сая төгрөгийн өрийг нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй зөвшилцөн хассан байна.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус сургууль нь 2022 онд нийт 2 хичээлийн байранд 560 сурагчдыг сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 505 сурагчдыг хамруулан сургаж, биелэлт 90,2 хувьтай байна.

021020323

Тус байгууллага нь тайлант онд 8 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 89.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлднэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОВ:



Х.БОЛДБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Төрөл (Code)	Бичлэг (Description)	Өмчийн үйлдвэрлэл	Дүнгийн үйлдвэрлэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>93,850,125.70</u></b>	<b><u>101,905,838.81</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	480,400.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	480,400.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	480,400.00
31211	Төрийн сангийн харилцах	-	480,400.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,672,700.70	18,672,513.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,337,700.70	300,054.31
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	13,335,000.00	18,372,459.50
3351	Байгууллагаас авах авлага	13,335,000.00	18,372,459.50
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,690,000.00	1,690,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	1,690,000.00	1,690,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,690,000.00	1,690,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	76,487,425.00	81,062,925.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	166,700.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,487,425.00	80,896,225.00
35440	Түлш, шатах тослох материал	9,600.00	9,600.00
35450	Барилгын засварын материал	2,118,591.00	2,118,591.00
35460	Хүнсний материал	4,307,300.00	8,716,100.00
35470	Бусад хангамжийн материал	70,051,934.00	70,051,934.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,574,754,032.75</u></b>	<b><u>3,637,019,351.18</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,574,754,032.75	3,637,019,351.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,529,456,605.77	3,591,721,924.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,496,294,650.00	3,500,373,650.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(97,249,987.60)	(130,148,580.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,791,234.00	211,121,234.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(132,905,512.08)	(137,636,262.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	151,131,360.16	205,399,108.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,993,909.69)	(98,176,735.43)
39217	Ном	33,388,770.98	40,789,509.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	45,297,426.98	45,297,426.98
39301	Програм хангамж	1,075,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(765,573.02)	(765,573.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,988,000.00	44,988,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,668,604,158.45</u></b>	<b><u>3,738,925,189.99</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,513,643.00</u></b>	<b><u>4,329,322.76</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,513,643.00	4,329,322.76
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,513,643.00	4,329,322.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,513,643.00	4,254,322.76
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	75,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,666,705,515.45</u></b>	<b><u>3,734,595,867.23</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,666,705,515.45	3,734,595,867.23

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837,165,419.00	837,165,419.00
51101	Өмч: - төрийн	837,165,419.00	837,165,419.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,964,548,032.73</b>	<b>2,032,438,384.51</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,964,548,032.73	1,964,548,032.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	67,890,351.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,992,063.72	864,992,063.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,668,219,158.45</u></b>	<b><u>3,738,925,189.99</u></b>

/Төгрөгөөр/

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,008,032,450.49</b>	<b>1,625,254,986.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,882,297,752.49</b>	<b>78,747,486.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,882,297,752.49</b>	<b>78,747,486.92</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,882,297,752.49	75,245,064.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,882,297,752.49	75,245,064.70
120005	Түрээсийн орлого	-	3,502,422.22
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,125,734,698.00</b>	<b>1,546,507,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,068,349,800.00</b>	<b>1,546,507,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	259,177,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,068,349,800.00	1,287,330,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>11,498,498.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,498,498.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,886,400.00</b>	<b>-</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,886,400.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,158,410,120.31</b>	<b>1,557,364,635.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,158,410,120.31</b>	<b>1,557,364,635.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,118,569,671.74</b>	<b>1,538,722,470.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>822,216,815.00</b>	<b>960,677,219.76</b>
210101	Үндсэн цалин	601,824,629.00	721,028,091.33
210102	Нэмэгдэл	220,238,077.00	217,050,209.52
210104	Урамшуулал	154,109.00	22,598,918.91
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>109,651,138.54</b>	<b>125,614,106.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	76,129,902.00	77,134,452.99
210202	Тэтгэмжийн даатгал	8,463,042.15	12,630,638.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,750,273.73	11,189,090.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,659,321.78	2,526,347.67
210205	Эрүүл мэндийн даатгал	16,648,598.88	22,133,576.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>50,398,099.50</b>	<b>206,824,040.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,527,295.50	11,851,240.50

210302	Түлш, халаалт	44,548,404.00	194,972,800.00
210303	Цэвэр, бохир ус	322,400.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,014,148.00</b>	<b>4,744,585.00</b>
210401	Бичиг хэрэг	774,647.00	-
210402	Тээвэр, шатахуун	650,900.00	3,719,085.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,700.00	1,025,500.00
210404	Ном, хэвлэл	161,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,081,251.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,812,150.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>72,932,352.00</b>	<b>141,067,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,477,200.00	-
210502	Хоол, хүнс	68,890,652.00	140,726,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,564,500.00	341,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,615,800.00</b>	<b>1,660,800.00</b>
210604	Урсгал засвар	5,615,800.00	1,660,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>874,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	874,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>530,000.00</b>	<b>6,666,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,666,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,337,318.70</b>	<b>91,467,768.49</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,557,843.00	23,201,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,079,100.00	9,515,579.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,700,375.70	58,750,918.51
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,840,448.57</b>	<b>18,642,165.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,118,700.00</b>	<b>18,642,165.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,118,700.00	18,642,165.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,721,748.57</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,721,748.57	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,849,622,330.18</u></b>	<b><u>67,890,351.78</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>296,250.04</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	296,250.04	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(296,250.04)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,849,326,080.14</u></b>	<b><u>67,890,351.78</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь өрөлцөөний НИЙТ ДҮН
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	1,964,548,032.73	3,666,705,515.45
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	1,964,548,	3,666,705,515.45

				032.73	
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	1,964,548,032.73	3,666,705,515.45
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	1,964,548,032.73	3,666,705,515.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	1,964,548,032.73	3,666,705,515.45
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	67,890,351.78	67,890,351.78
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419.00	864,992,063.72	2,032,438,384.51	3,734,595,867.23

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,125,734,698.00</b>	<b>1,546,764,907.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,125,734,698.00</b>	<b>1,546,764,907.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,068,349,800.00	1,546,507,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	259,177,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,068,349,800.00	1,287,330,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,498,498.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,498,498.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,886,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,886,400.00	-
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	257,407.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		257,407.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,125,734,698.00</b>	<b>1,546,284,507.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,125,734,698.00</b>	<b>1,546,284,507.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,085,525,249.43</b>	<b>1,507,368,400.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	821,179,156.93	947,835,200.00

210101	Үндсэн цалин	582,287,228.11	717,818,810.35
210102	Нэмэгдэл	188,713,128.82	210,304,088.70
210104	Урамшуулал	50,178,800.00	19,712,300.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	110,890,200.00	118,536,500.00
210201	Тэтгэврийн даатгал	78,033,900.00	80,501,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,214,000.00	9,388,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,571,300.00	7,670,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,642,800.00	1,886,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,428,200.00	19,089,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44,225,599.50	207,234,300.00
210301	Гэрэл, цахилгаан	10,390,599.50	11,381,500.00
210302	Түлш, халаалт	32,955,000.00	194,972,800.00
210303	Цэвэр, бохир ус	880,000.00	880,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,543,098.00	-
210401	Бичиг хэрэг	677,147.00	-
210402	Тээвэр, шатахуун	479,400.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,700.00	-
210404	Ном, хэвлэл	244,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,101,751.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,507,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	73,423,852.00	145,783,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	724,200.00	-
210502	Хоол, хүнс	70,135,152.00	144,583,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,564,500.00	1,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,615,800.00	1,660,800.00
210604	Урсгал засвар	5,615,800.00	1,660,800.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	154,000.00	-
210702	Дотоод албан томилот	154,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,020,000.00	7,692,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,300,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,692,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,473,543.00	78,625,700.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,605,043.00	67,087,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,868,500.00	11,538,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,209,448.57</b>	<b>38,916,107.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,487,700.00</b>	<b>38,916,107.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	257,407.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,487,700.00	38,658,700.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,721,748.57</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,721,748.57	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>=</b>	<b><u>480,400.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>480,400.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>480,400.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1546507500.00	1546027100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1546507500.00	1546027100.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1494703300.00	1507368400.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	948766700.00	947835200.00
210101	Үндсэн цалин	750116400.00	717818810.35
210102	Нэмэгдэл	178876000.00	210304088.70
210104	Урамшуулал	19774300.00	19712300.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	118595900.00	118536500.00
210201	Тэтгэврийн даатгал	80645100.00	80501300.00
210202	Тэтгэмжийн даатгал	9396600.00	9388100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7681300.00	7670700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1897500.00	1886500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18975400.00	19089900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	206243400.00	207234300.00
210301	Гэрэл, цахилгаан	10390600.00	11381500.00
210302	Түлш, халаалт	194972800.00	194972800.00
210303	Цэвэр, бохир ус	880000.00	880000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	132,638,200.00	145,783,700.00
210502	Хоол, хүнс	132,638,200.00	144,583,700.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,660,800.00	1,660,800.00
210604	Урсгал засвар	1,660,800.00	1,660,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,692,200.00	7,692,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,692,200.00	7,692,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,106,100.00	78,625,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,567,800.00	67,087,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,538,300.00	11,538,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51,804,200.00	38,658,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,804,200.00	38,658,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,804,200.00	38,658,700.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,546,507,500.00	1,546,507,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,546,507,500.00	1,546,507,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	259,177,000.00	259,177,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,287,330,500.00	1,287,330,500.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>480,400.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	71.00	71.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00
620004	Гэрээт ажилтан	10.00	10.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээл сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, өөрийн төлөвлөлттэй, бие даасан зөв хүүхэд төлөвшүүлнэ" гэсэн зорилготойгоор удирдах 1, бага ангийн багш 10, дунд ахлах ангийн багш 24, дотуур байрны багш 5, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургалтын менежер нар 4, ажилтан 8, үйлчлэх 19, нийт 71 орон тоотойгоор сургалтын үйл ажиллагааг явуулсан байна.

Ховд сумын сургуульд 23 бүлгийн 505 суралцагч, үүнээс эрэгтэй 257, эмэгтэй 248 сурагчтай. 320 хүүхдийн багтаамжтай хичээлийн хуучин байр, 240 хүүхдийн багтаамж бүхий хичээлийн шинэ байранд нийт 505 хүүхэд, 160 хүүхдийн багтаамж бүхий дотуур байранд 204 хүүхэд хүмүүжиж, сурлага хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургуульд 16 заах аргач, 11 мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй, 3 магистрын зэрэгтэй багш нар ажилласан байна.

2021- 2022 оны хичээлийн жилд бага боловсролыг 214 сурагч, суурь боловсролыг 158 сурагч, бүрэн дунд боловсролыг 103 сурагч, насан туршийн боловсролын 25 сурагч тус тус амжилттай суралцаж төгссөн байна. Тус сургуулийн хичээлийн жилийн элсэлтийн

ерөнхий шалгалтаар төгсөгчид нь аймгийн БШУГ-тай хийсэн гэрээгээр 508 оноо авах гэрээ байгуулснаас 524 оноо авч, 3 сурагч 740-793 оноо авсан амжилт үзүүлсэн байна

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2,2 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрч хугацаатай үүрэг өгөгдөж барагдуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ховд сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,3 сая төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0,5	0,5
Авлага	15,7	20,4	4,7
Бараа материал	76,4	81,1	4,7
Үндсэн хөрөнгө	3882,7	4003,7	121,0
Нийт хөрөнгө	3668,6	3738,9	70,3
Өр төлбөр	1,9	4,3	2,4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3666,7	3734,6	67,9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3668,6</b>	<b>3738,9</b>	<b>70,3</b>

Оны эхнээс авлага 4,7 сая төгрөгөөр буюу 29,9 хувиар өссөн, бараа материал 4,7 сая төгрөгөөр буюу 6,1 хувиар өссөн, үндсэн хөрөнгө 119,2 сая төгрөгөөр буюу 3,1 хувиар өссөн, өр төлбөр 2,4 сая төгрөгөөр буюу 126,3 хувиар өссөн, засгийн газрын хувь оролцоо 67,9 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн зэрэг өөрчлөлтүүд орсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1381,9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 94,6 сая дүнтэй багш нарын 5 жилийн тэтгэмжийг илүү тусгасныг хасаж 1287,3 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,287,3 сая төгрөгийг улсын төсвөөс, 259,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1287,3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 259,2 сая төгрөг, нийт 1546,5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, үйл ажиллагаандаа зарцуулсан байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1546,5 сая төгрөг буюу 100,0 хувьтай байгаа нь өмнөх оноос цалин хөлс нэмэгдэл урамшууллыг 126,6 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 7,6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 60,1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 231,5 сая төгрөгөөр, норматив зардал 72,4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардлыг 7,0 сая төгрөгөөр, бусал урсгал шилжүүлэг 17,2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсантай холбоотой байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81806/122005	205,7	205,7	0.00	100%
2	81834/120004	852,7	852,7	0.00	100%
3	81835/122005	488.1	488.1	0.00	100%
<b>Нийт дүн</b>		<b>1546,5</b>	<b>1546.5</b>	<b>0,00</b>	<b>100,0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсвийн санхүүжилт байхгүй

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Ховд сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эл Би Альфа Экспэйншин Аудит ХХК-ны аудитор Н.Дэмбэрэлдорж гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Ховд сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1208,6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 6,0 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 1625.2 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 8,1 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 6,5 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсвийн шууд захирагчийн төсөв өмч хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийг огт мэдээлээгүй, тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 128, хугацаа хоцроосон мэдээлэл 9 байна

##### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн нийт 4,4 сая төгрөгийн төлбөр, зөрчил, залруулга илрүүлж, төлбөрийн акт 2,0 сая төгрөгийн НДШ-ийг илүү төлж авлагаар тусгаагүй, залруулга 0,6 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг тайланд тусгаагүй, албан шаардлага 1,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг гэрээгээр бэлтгүүлсэн боловч хүлээн аваагүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, жолоочийн замын хуудас гарын үсэггүй, худалдан авсан бараа материалыг и баримтаар баталгаажуулаагүй, засгийн газрын 43 тоот тогтоолын дагуу батлагдсан төсвөөс хэмнэлт гаргаагүй зэрэгт 183,8 сая төгрөгийн акт, албан шаардлага, зөвлөмж бичиж хэрэгжүүлэх хугацаатай үүрэг өгөгдснөөс албан шаардлагаас бусад нь бүрэн хэрэгжсэн байна

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/сая төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,0	2	2,0	100%
Албан шаардлага	1	1,7			0%
Зөвлөмж	3	183,8	3	183,8	100%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>187,5</b>	<b>5</b>	<b>185,8</b>	<b>99,1%</b>

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Он дамжсан авлагыг барагдуулаагүй тул хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр акт тогтоож барагдуулах шаардлагатай гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс тул аудитын тайланд авлагаар бүртгүүлсэн 1.7 сая төгрөгийн акт тогтоож, 4,1 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар нийт 0.4 сая төгрөгийн алдаа илэрч залрууллаа.Үүнд:

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Төсвөөс 0.4 сая төгрөг шилжүүлж, авлага бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага тусгаагүй орхигдуулсан	1	0.4	1	0.4			1	0.4				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.4</b>	<b>1</b>	<b>0.4</b>			<b>1</b>	<b>0.4</b>				

**Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө оршин байхгүй, өмнөх оны шийдвэр хэрэгжээгүй	1	1.7	1	1.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1.7</b>	<b>1</b>	<b>1.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
шатахууны зардалтай холбоотой асуудал	1	4.1					1	4.1
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>4.1</b>					<b>1</b>	<b>4.1</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

*Х. Болдбаатар* Х. БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А. ЦЭЦЭГСҮРЭН

**ТАЙЛАНГ БИЧСЭН**

ЭЛ БИ АЛЬФА ЭКСПЭЙНШИН АУДИТ ХХК- ний

АУДИТОР:

*Н.Дэмбэрэлдорж*

Н.ДЭМБЭРЭЛДОРЖ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 25/А 2160 424

Ховд

ХОА-2022/112/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд 2020 онд бэлтгэн нийлүүлэхээр гэрээ байгуулсан 1,690.0 мянган төгрөгийн хөрөнгийг нийлүүлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 5.4-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсантай холбоотой 1690000/ нэг сая зургаан ерөн мянган төгрөг / -ийг Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх.
2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ховд сумын ЕБС-ийн захирал Э.Уатхан, нягтлан бодогч Ж.Болатбек нарт тус тус хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ